**Аймгийн Засаг даргын Тамгын газрын**
**“Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг**
**2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт**

2018.12.07 Чойр хот

| д/д | Тухайн жилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ | Хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлт, тоо хэмжээ, хугацаа | Хугацаа Хариуцах хэлтэс, тасаг | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1. Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшлыг хууль тогтоомжийн дагуу олгох.** | | | | | |
| 1 | Төрийн албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн цалингийн шатлал ахиулан олгох; | -Шалгуур хангасан албан хаагчдын цалингийн шатлалыг нэмэгдүүлсэн байна. | - ТАЗ-ийн 2012 оны 134 дүгээр тогтоолын дагуу урамшуулал олгогдсон байна.<br>- 2018 он, 01 дүгээр улиралд 1 удаа | Төрийн албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн төрийн захиргааны 11, төрийн үйлчилгээний 2 албан хаагчийн цалингийн шатлалыг ахиулан олгосон. | 100 |
| 2 | Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ур чадварыг харгалзан зэрэг дэв нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэх; | -Засаг даргын захирамжаар зэрэг дэв олгогдсон албан хаагчдын зэрэг дэвийн нэмэгдлийг олгосон байна. | - ТАЗ-ийн 2012 оны 134 дүгээр тогтоолын дагуу болзол хангасан албан хаагчдын материалыг бэлтгэн ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж, зэрэг дэв олгуулсан байна.<br>- 2018 он, 1 удаа, 1-р улиралд | Аймгийн Засаг даргын 2018 оны А/19 дугаар захирамжаар 2018 онд аймгийн ЗДТГ-ын 7 албан хаагчид зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгуулахаар шийдвэр гаргуулсан. | 100 |
| 3 | Төрийн албан хаагчийн цалин, нэмэгдэл хөлс, нөхөх төлбөр, тусламж, дэмжлэгийг холбогдох хууль журам, байгууллагын дотоод журмын дагуу тухай бүр | - Хуулийн дагуу албан хаагчдын цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг бүрэн олгосон байна.<br>- Шагнал, урамшуулал болон бусад тусламж, дэмжлэгийг дотоод журмын дагуу олгосон байна. | - Холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэгдсэн байна.<br>- 2018 он, жилдээ | Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу 20 албан хаагчид 5,7 сая төгрөгийн буцалтгүй тусламж, шинэ хүүхэдтэй болсон 7 албан хаагчид 700,0 мянган төгрөгийн дэмжлэг, хүүхдийнхээ сэвлэгийг үргээсэн 1 албан хаагчид 200,0 мянган төгрөгийн дэмжлэг, албан тушаалын зэрэглэлийн хурандаа цол авсан 1 албан хаагчид 300,0 мянган төгрөгийн урамшуулал дэмжлэгийг тус тус олгосон байна. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | шийдвэрлэж байх; | | | | |
| 4 | Гэр хороололд амьдарч байгаа ажилтан, албан хаагчдад түлээ, нүүрсний тусламж үзүүлэх | - Гэр хороололд амьдарч байгаа ажилтан албан хаагчдын судалгааг гаргасан байна.<br>- Гэр хороололд амьдарч байгаа ажилтан, албан хаагчдыг бүрэн хамруулсан байна. | - | 2018 оны 12 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдаас гэр хороололд амьдардаг нийт 12 албан хаагчид 24 тн нүүрс олгосон. | 100 |
| 5 | Үйл ажиллагааны үр дүн, ажлын бүтээмж онцлогийг харгалзан албан хаагчдыг гадаад дотоодын сургалтанд хамруулах; | - Засгийн газар, яам, тамгын газраас зохион байгуулж байгаа сургалтанд холбогдох албан хаагчдыг хамруулах<br>- Удирдлагын академи болон бусад сургалтын байгууллагаас зохион байгуулж байгаа сургалтанд албан хаагчдыг хамруулах<br>- Бусад төрийн болон төрийн бус байгууллагаас зохион байгуулж байгаа сургалтанд чиглэлийн мэргэжилтэн, албан хаагчдыг хамруулах<br>- Шаардлагатай албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр сургалтанд хамруулахад дэмжлэг үзүүлэх<br>- Гадаад улсан туршлага судлах, уулзалт, зөвлөгөөнд оролцуулах, сургалтанд хамрагдах нөхцөл боломжоор хангах | - Сургалтын үр дүнд албан хаагчдын ажлын бүтээмж дээшилсэн байна.<br>- 2018 он, жилдээ | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон бусад яам агентлагуудаас зохион байгуулах сургалтуудад албан хаагчдыг чиглэл чиглэлийн дагуу бүрэн хамруулж байна. 2018 оны байдлаар давхардсан тоогоор нийт 151 албан хаагчийг албан томилолтоор сургалт, уулзалт, зөвлөгөөнд хамруулсан байна.<br>Удирдлагын академийн магистрын зэрэг олгох ангид ХОХБТХ-ийн дарга, Удирдлагын академийн мэргэшүүлэх дипломын сургалтын элсэлтийн шалгалтад ХЭЗХ-ийн дарга, ХОХБТХ-ийн мэргэжилтэн орсон ба ХЭЗХ-ийн дарга суралцах эрх авсан. Байгууллагын зүгээс суралцах боломжоор ханган ажиллаж байна. Мөн Удирдлагын академийн “Төрийн албан хаагчийн манлайлах ур чадвар”, “Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцаа, эрх зүйн зохицуулалт” сэдэвт зайн сургалтад ТЗУХ-ийн Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, ХЭЗХ-ийн Гэрээний хяналт, архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтэн, ХШҮДАХ-ийн<br>Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнийг хамруулсан ба 1 мэргэжилтэн сертификат авсан.<br>Аймгийн ЗДТГ-аас Гадаад улсад туршлага судлах, уулзалт, зөвлөгөөнд оролцуулах, сургалтанд хамрагдах нөхцөл боломжоор | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | хангаж ажилласны үр дүнд 6 албан хаагч гадаадад туршлага судалж, сургалт, зөвлөгөөнд хамрагдсан. Зүүн хойд Азийн засаг захиргаадын холбоо (NEAR)-ны үйл ажиллагаанд тогтмол идэвхитэй оролцож аймгийн Засаг дарга БНХАУ-д, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга С.Уранцэцэг Солонгос улсад, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотод зохион байгуулагдах аравдугаар удаагийн “Хятад, Монгол, Оросын эдийн засаг худалдааны хамтын ажиллагааны чуулга уулзалт”-нд аймгийн Засаг даргын орлогч, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга нар, Үр дүнг сайжруулах үйл ажиллагаа сэдэвт сургалт Солонгос улсад ХШҮДАХ-ийн дарга, Монголын Хөдөө аж ахуйн машин механизмын практик сургалтанд БНХАУ-д 1 сарын хугацаатай ХОХБТХ-ийн мэргэжилтэн тус тус хамрагдсан байна. | |
| 6 | Аливаа уралдаан, тэмцээнд оролцож, мөн ажлын амжилт гаргасан албан хаагчдыг шагнаж, урамшуулах; | - Байгууллагын аварга ажилтныг шалгаруулах<br>- Аймаг, сумдын Засаг даргын шагналд ажилтан, албан хаагчдыг тодорхойлж, шийдвэрлүүлэх<br>- Төрийн дээд болон салбарын шагналд ажилтан, албан хаагчдыг тодорхойлж, шийдвэрлүүлэх | - Албан хаагчдын идэвхи нэмэгдэж, ажлын үр дүн дээшилсэн байна.<br>- 2018 он, жилдээ | Аймгийн Засаг даргын нэрэмжит “Боржигин түмний дуулал-2018” урлагийн наадамд амжилттай оролцож шагналт байр эзэлж, шилдэг үзүүлбэрийн нэгдсэн тоглолтонд оролцсон 21 албан хаагчид 2250,0 мянган төгрөгийн урамшуулал олгосон. Мөн эрхэлсэн ажилдаа ур чадвар, мэдлэг оюунаа зориулан хамт олноо манлайлан ажилласан 1 албан хаагчийг 50,0 мянган төгрөгөөр шагнасан. | 100 |
| **Зорилт 2. Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөл, боломжоор хангах.** | | | | | |
| 7 | Албан хаагчдын хэрэгцээнд тулгуурлан бичиг хэрэгсэл, шаардлагатай бусад материал, | - Албан хаагчдыг шаардлагатай бичгийн хэрэгслээр хангах.<br>- Байгууллагын төсөвт багтаан албан хаагчдад шаардлагатай техник, | - Албан хаагчдын ажиллах нөхцөл бүрдэж, ажлын бүтээмж дээшилсэн байна.<br>- 2018 он, 1 удаа, 1 жилийн турш | Албан хаагчдын ажлын хэрэгцээнд тулгуурлан бичиг хэрэгсэл болон компьютер, хувилах машин зэрэг шаардлагатай техник хэрэгслээр байнга хангаж ажиллаж байна. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | техник хэрэгслээр хангах, ажлын байрны нөхцлийг сайжруулах; | хэрэгслийг шинэчлэх, шинээр авах | | | |
| 8 | Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх | - Шаардлагатай ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулж, мөрдүүлэх | - Ажлын цаг ашиглалт, үр бүтээл сайжирч, ажилтан, албан хаагчийн ачааллыг бодитой тооцсон байна. | Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Ажлын байрны тодорхойлолт боловсруулах заавар”-ын дагуу албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг 2018 оны 01 дүгээр сард шинэчлэн боловсруулсан. | 100 |
| 9 | Шинээр томилогдсон албан хаагчдыг Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлэх | - ТАЗСЗөвлөлд тангараг өргөх ажилтан, албан хаагчдыг танилцуулж, шийдвэрлүүлэх | - Засаг даргын шийдвэрээр албан хаагчийг тангараг өргүүлсэн байна. | Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгч тэнцэн, туршилтаар ажиллаж байх хугацаандаа цаашид төрийн албанд үр бүтээлтэй ажиллаж чадахаа нотлон харуулсан аймгийн ЗДТГ-ын Гэрээний хяналт, архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан мэргэжилтэн Телегиний Багатгуль 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөж төрийн жинхэнэ албан хаагч болсон. | 100 |
| **Зорилт 3. Орон сууцны нөхцлөө сайжруулах, орон байраар хангагдахад нь хөрөнгө санхүүгийн болон зохих туслалцаа, дэмжлэг үзүүлэх.** | | | | | |
| 10 | Төрийн албан хаагчийг амьдрах орчин нөхцлөө сайжруулах, шинээр орон сууц худалдан авахад зохих хэмжээний тусламж, дэмжлэгийг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу үзүүлэх; | - Байгууллагын ажилтан, албан хаагч шинэ гэр барих, шинээр орон сууцанд ороход нь дотоод журмын дагуу дэмжлэг үзүүлнэ.<br>- Орон сууцны хөнгөлөлттэй зээлэнд хамрагдахад мөрдөгдөж байгаа журмын дагуу дэмжлэг үзүүлнэ. | - Санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. | Төрийн албан хаагчийг амьдрах орчин нөхцлөө сайжруулах, шинээр орон сууц худалдан авахад байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу байнга дэмжиж ажилладаг. 2018 онд шинээр орон сууц худалдан авсан албан хаагч байхгүй байна. | - |
| 11 | Албан хаагчдыг орон сууцаар хангах | - Журамд заасны дагуу холбогдох албан тушаалтнуудыг орон | - Журмын хэрэгжилтийг хангаж ажилласан байна.<br>- Шаардлагатай ажилтан, | Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан тушаалын байранд аймгийн Засаг дарга байдаг болно. 2018 онд албан хаагчдаас | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | сууцаар хангана.<br>- Шаардлагатай тохиолдолд байгууллагын орон сууцыг албан хаагчдад түрээслүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | албан хаагчийг орон сууцаар хангасан байна. | албаны орон сууц түрээслэх хүсэлт ирээгүй. | |
| **Зорилт 4. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж чанарыг дээшлүүлэх.** | | | | | |
| 12 | Идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамирын уралдаан тэмцээн, бэлтгэл сургуулилтыг олон хэлбэрээр зохион байгуулах; | - Байгууллагын албан хаагчдыг биеийн тамир, спортын уралдаан, тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлнэ.<br>- Уралдаан, тэмцээнд оролцоход бэлтгэл, сургуулилт хийх боломж, нөхцлөөр хангана.<br>- Уралдаан тэмцээнд оролцоход хувцас болон бусад шаардлагатай материалаар хангана. | - Албан хаагчдыг 100 хувь хамруулсан байх.<br>- Шаардлагатай албан хаагчдад чөлөө олгох, санхүүгийн болон материалын тусламж, дэмжлэг үзүүлсэн байна.<br>- 3-аас доошгүй удаа, жилдээ | Аймгийн ЗДТГ-ын албан хаагчдыг биеийн тамираар хичээллэх боломжоор хангаж Биеийн тамир, спортын газрын спорт заалыг 7 хоног бүрийн Лхагва гаригт түрээсэлж албан хаагчдыг хамруулж байна.<br>Албан хаагчдыг уралдаан тэмцээнд өмсөхөд зориулж гар бөмбөг, сагсан бөмбөгийн тус бүр 8 өмсгөл авсан.<br>Албан хаагчдын дунд биеийн тамирын уралдаан тэмцээнийг 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн 7 хоног тутамд нэг уралдаан тэмцээн зохион байгуулж, холбогдох зардлыг нь шийдвэрлэн өгч ажиллаж байна. | 100 |
| 13 | Тогтмол өдөр биеийн тамираар хичээллэх боломжоор хангах | - Байгууллагын албан хаагчдыг биеийн тамираар хичээллэх боломжоор хангаж спорт заал түрээслэх асуудлыг шийдвэрлэнэ.<br>- Байгууллага, хамт олны дунд уралдаан, тэмцээн зохион байгуулж, дотоод журамд заасны дагуу урамшуулна. | - Байгууллагын ажилтан, албан хаагчдыг бүрэн хамруулж, үйл ажиллагаа жигдэрсэн байна. | Аймгийн ЗДТГ-ын албан хаагчдыг биеийн тамираар хичээллэх боломжоор хангаж Биеийн тамир, спортын газрын спорт заалыг 7 хоног бүрийн Лхагва гаригийн 19.30-21.30 цаг хүртэл түрээсэлж албан хаагчдыг бүрэн хамруулдаг. | 100 |
| 14 | Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах; | - Нийт албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулна.<br>- Шаардлагатай тохиолдолд эмчлүүлэх нөхцөл боломжоор хангаж, дотоод журамд заасны | - Байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт 100 хувь хамруулсан байна. | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах 51 албан хаагчийн судалгааг гаргаж аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүргүүлж, 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. | 100 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дагуу тусламж, дэмжлэг үзүүлнэ. | | | |
| **Зорилт 5. Амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах.** | | | | | |
| 15 | Нийтийг хамарсан тэмдэглэлт өдөр, баяруудыг хамт олноороо тэмдэглэн өнгөрүүлэх; | - Шинэ жил, Цагаан сар, Улсын их баяр наадам болон эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, эр цэргийн баяр, Эх, үрсийн баяр, Ахмадын баярыг хамт олноороо тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулна.<br>- Төрсөн өдөр нь тохиож байгаа ажилтан, албан хаагчдад баяр хүргэж, дурсгалын зүйл гардуулах | - Тэмдэглэлт 2-оос доошгүй арга хэмжээг хамт олноороо тэмдэглэн өнгөрүүлсэн байна.<br>- Нийт хамт олныг хамруулсан байна | 2018 онд Цагаан сар, Улсын их баяр наадам болон эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, эр цэргийн баяр, Эх, үрсийн баяр зэрэг нийтийг хамарсан тэмдэглэлт баяруудыг хамт олноороо тэмдэглэн өнгөрүүлсэн. Мөн төрсөн өдөр нь тохиож байгаа ажилтан, албан хаагчдад баяр хүргэж, дурсгалын зүйлд ном гардуулан өгч хэвшээд байна. | 100 |
| 16 | Байгалийн үзэсгэлэнт газраар аялах танин мэдэхүйн идэвхитэй амралт зохион байгуулах; | - Байгууллагын цасны баярыг зохион байгуулж, хамт олноо бүрэн хамруулна.<br>- Зуны амралтыг зохион байгуулж, хамт олноо бүрэн хамруулна. | - Байгалийн үзэсгэлэнт 1-ээс доошгүй газраар аялсан байна.<br>- Нийт хамт олныг хамруулсан байна. | - Байгууллагын цасны баярыг 2018 оны 03 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд зохион байгуулж, хамт олноо бүрэн хамруулсан. Мөн 2018 оны 07 дугаар сарын 16-21-ний өдрүүдэд зуны амралтыг зохион байгуулж, хамт олноороо байгалийн үзэсгэлэнт Итгэлт хамба, Байгаль нуураар аялсан. | 100 |
| 17 | Байгууллага, хамт олноороо нийтийг хамарсан бүтээлч арга хэмжээнд оролцох | - Бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд байгууллагын эзэмшлийн болон нийтийн эдэлбэр газарт мод, бут тарих.<br>- Чойрын богд уулын орчимд хог хаягдлыг цэвэрлэх<br>- Амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрх, хүүхэд, өндөр настанд туслах.<br>- Орон нутагт бий болсон гамшиг, ослын үед тусламж, хандив өгөх, сайн дурын арга хэмжээнд оролцох | - Сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлсэн байна.<br>- Нийт хамт олныг хамарсан байна. | - Бүх нийтээр мод тарих үндэсний өдрийн хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газраас нийтйин эдэлбэр газарт 150 ширхэг мод, байгууллагын эзэмшлийн талбайд 21 ширхэг мод сөөгийг нөхөн тарилт хэлбэрээр тарьж давхардсан тоогоор 65 албан хаагч оролцон 280000 төгрөгийг зарцуулсан байна.<br>Бүх нийтийн хог хаягдал цэвэрлэх ажлын дагуу 2 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 56 албан хаагчийг хамруулж 2 га орчим талбайд тархсан хог хаягдлыг цэвэрлэсэн байна. | 70 |

| | |
|---|---|
| **Биелэлт** | **98%** |

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**